

## БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ (2023 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

### Судалгааны товч үр дүн

Банкуудаас 2023 оны 4 дүгээр сарын 13-19-ний өдрийн хооронд санал асуулга хэлбэрээр өнгөрсөн болон ирэх 3 сарын хугацааны зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулан нэгтгэж, тайлан боловсруулав. Үр дүнг товч танилцуулбал:

#### Зээлийн шалгуур

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол жижиг болон дунд банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд ерөнхийдөө зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна.

#### Зээлийн нөхцөл

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй бол иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулжээ. Харин дунд болон жижиг банкууд зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах хүлээлттэй байна.

#### Зээлийн эрэлт

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том болон дунд банкуудын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгджээ. Харин жижиг банкуудын зээлийн эрэлтэд өөрчлөлт ороогүй байна.
- Ирэх 3 сард том банкууд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол дунд болон жижиг банкууд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

#### Зээлийн нийлүүлэлт

- Ирэх 3 сард том болон дунд банкууд зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Харин жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах хандлагатай байна.

### Хүснэгт 1.1 Судалгааны нэгдсэн үр дүн

Банкууд / Зээлийн төлөв	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт		Зээлийн нийлүүлэлт	
	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд
Өнгөрсөн 3 сарын хугацаанд								
Том	↓	↓	0	↓	↑	↑		
Дунд	0	0	0	0	↑	↑		
Жижиг	0	0	0	0	0	0		
Ирэх 3 сарын хугацаанд								
Том	0	0	0	0	↑	↑	↑	↑
Дунд	0	↑	0	0	0	0	↑	↑
Жижиг	0	0	0	0	0	0	0	0

Тэмдэглэл: ↑ бага зэрэг нэмэгдсэн; ↑↑ мэдэгдэхүйц нэмэгдсэн; 0 өөрчлөгдөөгүй; ↓ бага зэрэг буурсан; ↓↓ мэдэгдэхүйц буурсан

## Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь банкуудаас олгож буй зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон нийлүүлэлт, тэдгээрийн цаашдын төлөвийг тодорхойлоход оршино.

## Судалгааны хамрах хүрээ

Банкны зээлийн төлөвийн судалгаанд нийт 12 банкыг хамруулсан бөгөөд тухайн банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудаас асуулга авсан болно.

## Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгаа нь санал асуулга хэлбэрээр зохион байгуулагддаг бөгөөд (i) зээлийн шалгуур, (ii) зээлийн нөхцөл, (iii) зээлийн эрэлт болон (iv) зээлийн нийлүүлэлт гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ [-1;+1] хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 1.2-т өгөгдсөн байдлаар индексэд хөрвүүлдэг.

Хүснэгт 1.2 Индексийн тооцоолол					
Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн эрэлт	Нэлээд багассан/багасна	Бага зэрэг багассан/багасна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн/нэмэгдэнэ	Нэлээд нэмэгдсэн/нэмэгдэнэ
Зээлийн нийлүүлэлт	Нэлээд бууруулна	Бага зэрэг бууруулна	Өөрчлөгдөхгүй	Бага зэрэг нэмэгдүүлнэ	Нэлээд нэмэгдүүлнэ


Нийт системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцсон болно. Тухайн хугацаан дахь ерөнхий индексийн утга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх өнгөрсөн 3 сарын байдал болон ирэх 3 сарын төлөвийг илэрхийлнэ.

# I. Зээлийн шалгуур

## 1.1 Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуур

- Банкуудын ААН-ийн зээлийн шалгуур 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 оны I улирлаас эхлэн 4 улирлын турш сулрах мужид байжээ. Харин 2022 оны I улирлаас эхлэн банкууд зээлийн шалгуураа чангаруулж эхэлсэн байна. 2023 оны I улиралд банкууд ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ирэх улиралд банкууд ААН-ийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 1).

**Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуур ба хүлээлт**




- Банкууд 2023 оны I улиралд ХАА, боловсруулах үйлдвэр болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулсан бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. 2023 оны II улиралд худалдаа, үйлчилгээнээс бусад салбаруудын зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. ААН-ийн зээлийн шалгуур, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.I улирлын хүлээлт	-0.18	-0.24	0.16	-0.14	0.42	-0.17
2023.I улирлын үр дүн	-0.22	-0.23	0	-0.19	0	-0.33
2023.II улирлын хүлээлт	0.01	0	0	0	0	-0.10

- 2023 оны I улиралд ААН-ийн зээлийн шалгуурыг сулруулахад нөлөөлсөн хүчин<sup>1</sup> зүйлсийг авч үзвэл эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон банкны эрсдэл даах чадвар сайжирсан нь голлон нөлөөлжээ (Зураг 2).

**Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс**




<sup>1</sup> Хавсралт 1-д ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлсөн хүчин зүйлсийг дэлгэрэнгүй тусгав

## 1.2 Иргэдийн зээлийн шалгуур

- Банкуудын иргэдийн зээлийн шалгуур 2020 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2022 оны I улирлаас эхлэн 4 улирлын турш чангарах мужид байжээ. Харин 2023 оны I улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарчээ. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах хандлагатай байна (Зураг 3).

**Зураг 3. Иргэдийн зээлийн шалгуур ба хүлээлт**




- Банкууд 2023 оны I улиралд автомашины зээлээс бусад зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан нь өмнөх улирлын хүлээлттэй ерөнхийдөө нийцтэй гарсан байна. Ирэх улиралд тэтгэврийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулж, хэрэглээний зээлийн шалгуураа бага зэрэг сулруулж, бусад төрлийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Иргэдийн зээлийн шалгуур, зээлийн ангиллаар**

Хугацаа	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2023.I улирлын хүлээлт	-0.24	-0.24	0.42	-0.19	-0.30	-0.30	-0.34
2023.I улирлын үр дүн	-0.50	-0.52	-0.41	-0.38	-0.55	-0.53	0
2023.II улирлын хүлээлт	0.06	0	0.39	-0.22	0	0	0

- 2023 оны I улиралд иргэдийн зээлийн шалгуурыг сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг<sup>2</sup> авч үзвэл эдийн засгийн нөхцөл байдал, банкны эрсдэл даах чадвар болон өрсөлдөөн голлон нөлөөлжээ (Зураг 4).

**Зураг 4. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс**




<sup>2</sup> Хавсралт 2-т иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлсөн хүчин зүйлсийг дэлгэрэнгүй тусгав

## II. Зээлийн нөхцөл

### 2.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөл

- Банкуудын ААН-ийн зээлийн нөхцөл 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 оны I улирлаас эхлэн огцом суларч, цаашид 5 улирлын турш сулрах мужид байжээ. Харин 2022 оны II улирлаас эхлэн чангарч эхэлсэн байна. 2023 оны I улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй бол ирэх улиралд бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 5).

Зураг 5. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт




- Банкууд 2022 оны IV улиралд дийлэнх салбаруудын зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулсан бол 2023 оны I улиралд ХАА, боловсруулах үйлдвэр болон худалдаа, үйлчилгээний салбаруудын зээлийн нөхцөлийг бага зэрэг сулруулсан байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2022.IV улирлын үр дүн	0.20	0.16	0.09	0.17	0.16	0.15
2023.I улирлын үр дүн	0	-0.13	0.08	-0.05	0.04	-0.09

- 2023 оны I улиралд банкууд ААН-ийн зээлийн хүүг өсгөх болон зээлдэгчийн гэрээгээр хүлээх үүргийг нэмэгдүүлэх зэргээр нөхцөлөө чангаруулсан бол зээлийн хугацааг нэмэгдүүлэх болон барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр нөхцөлөө сулруулжээ (Зураг 6).

Зураг 6. ААН-ийн зээлийн нөхцөлүүд




- Хүснэгт 4-т банкуудаас ААН-д тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү) болон жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа)-г түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү ба хугацааны индекстэй харьцуулан эдийн засгийн салбаруудаар харуулав. 2023 оны I улиралд уул уурхай, барилга болон худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн ЖДХүү өмнөх улирлаас өссөн бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин боловсруулах үйлдвэрийн хувьд эсрэг үр дүн гарчээ. Боловсруулах үйлвэр болон худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн ЖДХугацаа өссөн нь түүвэр судалгаагаар банкууд тус салбаруудад олгосон зээлийн хугацааг бага зэрэг нэмэгдүүлсэн гэсэн үр дүнтэй нийцтэй гарсан байна.

<b>Хүснэгт 4. ААН-д олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар</b>						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Банкуудын зээлийн ЖДХүү (хувь)	- 2022.IV улирал	14.3	13.0	15.0	17.9	15.3
	- 2023.I улирал	18.0	15.2	13.0	18.4	17.5
	- Өөрчлөлт	<u>+3.7</u>	<u>+2.2</u>	<u>-2.0</u>	<u>+0.5</u>	<u>+2.2</u>
Зээлийн хүү (судалгааны үр дүн)	2023.I улирал	0	0.42	0.18	0.19	0.14
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2022.IV улирал	34.9	5.4	19.1	25.9	28.2
	- 2023.I улирал	28.2	13.3	28.1	22.2	38.4
	- Өөрчлөлт	<u>-6.7</u>	<u>+7.9</u>	<u>+9.0</u>	<u>-3.7</u>	<u>+10.2</u>
Зээлийн хугацаа (судалгааны үр дүн)	2023.I улирал	-0.23	0	-0.14	0	-0.18

## 2.2 Иргэдийн зээлийн нөхцөл

- Банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө 2021 оны I улирлаас эхлэн сулруулж байсан бол 2022 оны II улирлаас эхлэн чангаруулж эхэлсэн байна. 2023 оны I улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарлаа. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө хэвээр нь хадгалах төлөвтэй байна (Зураг 7).

**Зураг 7. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт**




- Банкууд 2022 оны IV улиралд бүх төрлийн зээлийн нөхцөлийг бага зэрэг чангаруулсан бол 2023 оны I улиралд бага зэрэг сулруулах хандлагатай байна (Хүснэгт 5).

### Хүснэгт 5. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл, зээлийн төрлөөр

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2022.IV улирлын үр дүн	0.2	0.19	0.11	0.15	0.25	0.14	0.16
2023.I улирлын үр дүн	-0.1	-0.06	-0.16	-0.11	-0.11	-0.16	-0.04

- 2023 оны I улиралд банкууд иргэдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх болон барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр иргэдийн зээлийн нөхцөлийг сулруулсан байна (Зураг 8).

Зураг 8. Иргэдийн зээлийн нөхцөлүүд



- Хүснэгт 6-д банкуудаас иргэдэд тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү) болон жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа)-г түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү ба хугацааны индекстэй харьцуулан зээлийн төрлөөр харуулав. 2023 оны I улиралд тэтгэвэр, хэрэглээ болон автомашины зээлийн ЖДХүү өмнөх улирлаас өссөн бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй байна. Харин цалингийн зээлийн хүүний хувьд эсрэг үр дүн гарчээ. Тэтгэвэр болон хэрэглээний зээлийн ЖДХугацаа нэмэгдсэн нь түүвэр судалгаагаар банкууд тус зээлүүдийн хугацааг бага зэрэг нэмэгдүүлсэн гэсэн үр дүнтэй нийцтэй гарсан байна.

### Хүснэгт 6. Иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар


Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Малчны зээл	Автомашинны зээл
Банкуудын зээлийн ЖДХүү (хувь)	- 2022.IV улирал	16.8	15.6	20.3	20.9	18.4
	- 2023.I улирал	17.2	15.8	21.8	20.2	19.8
	- Өөрчлөлт	<u>+0.4</u>	<u>+0.3</u>	<u>+1.6</u>	<u>-0.7</u>	<u>+1.4</u>
Зээлийн хүү (судалгааны үр дүн)	2023.I улирал	-0.02	0.02	0.09	0	0.14
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2022.IV улирал	29.5	9.8	27.1	23.0	29.7
	- 2023.I улирал	28.4	13.6	31.6	23.0	32.3
	- Өөрчлөлт	<u>-1.1</u>	<u>+3.8</u>	<u>+4.5</u>	<u>0</u>	<u>+2.6</u>
Зээлийн хугацаа (судалгааны үр дүн)	2023.I улирал	-0.01	-0.39	-0.17	0	0

### Ш. Зээлийн эрэлт

#### 3.1 Аж ахуйн нэгжийн зээлийн эрэлт

- ААН-үүдийн зээлийн эрэлт 2018 оноос хойш 2020 оны I болон II улирлаас бусад үед “нэмэгдэх” мужид байсан байна. 2023 оны I улиралд ААН-ийн зээлийн эрэлт нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарчээ. Ирэх улиралд ААН-ийн зээлийн эрэлт мөн нэмэгдэх төлөвтэй байна (Зураг 9).

Зураг 9. ААН-ийн зээлийн эрэлт ба хүлээлт




- 2023 оны I улиралд ихэнх салбаруудын зээлийн эрэлт өссөн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ялангуяа, ХАА болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт бусад салбаруудтай харьцуулахад өндөр байжээ. 2023 оны II улиралд мөн ХАА, боловсруулах үйлдвэр болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх төлөвтэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. ААН-ийн зээлийн эрэлт, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.I улирлын хүлээлт	0.49	0.43	0.19	0.16	0.08	0.34
2023.I улирлын үр дүн	0.57	0.41	0.10	0.16	0.21	0.65
2023.II улирлын хүлээлт	0.67	0.69	0.16	0.42	0.29	0.68

- 2023 оны I улиралд ААН-ийн зээлийн эрэлт<sup>3</sup> нэмэгдэхэд эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 10).

Зураг 10. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс




<sup>3</sup> Хавсралт 3-т ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийг дэлгэрэнгүй тусгав.



### 3.2 Иргэдийн зээлийн эрэлт

- Иргэдийн зээлийн эрэлт 2018 оноос хойш нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2021 оны III улирлаас “нэмэгдэх” мужид байсаар байна. 2023 оны I улиралд иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан бөгөөд ирэх улиралд мөн бага зэрэг нэмэгдэх хүлээлттэй байна (Зураг 11).

**Зураг 11. Иргэдийн зээлийн эрэлт ба хүлээлт**




- 2023 оны I улиралд бүх төрлийн зээлийн эрэлт нэлээд нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ялангуяа тэтгэврийн зээлийн эрэлт нэлээд өссөн байна. 2023 оны II улиралд автомашины зээлээс бусад бүх төрлийн зээлийн эрэлт нэмэгдэх хүлээлттэй байна (Хүснэгт 8).

**Хүснэгт 8. Иргэдийн зээлийн эрэлт, зээлийн төрлөөр**

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2023.I улирлын хүлээлт	0.68	0.77	0.98	0.74	0.71	1.00	0.58
2023.I улирлын үр дүн	0.48	0.78	0.97	0.53	0.75	0.73	0.50
2023.II улирлын хүлээлт	0.38	0.38	0.81	0.43	0.67	0.50	0

- 2023 оны I улиралд иргэдийн зээлийн эрэлт<sup>4</sup> нэмэгдэхэд удаан эдэлгээт барааны худалдан авалт болон эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн итгэл нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 12).

**Зураг 12. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс**




<sup>4</sup> Хавсралт 4-т иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийг дэлгэрэнгүй тусгав.

## IV. Зээлийн нийлүүлэлт

### 4.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нийлүүлэлт

- Банкуудын ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн хүлээлт 2021 оноос хойш “нэмэгдэх” мужид байсаар байна. 2023 оны I улиралд банкууд ААН-д олгох зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлнэ гэж хүлээж байсан бол ирэх улиралд нэлээд нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 13).

**Зураг 13. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл**



- Банкууд 2023 оны II улиралд ихэнх салбаруудад олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна. Ялангуяа ХАА болон худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 9).


**Хүснэгт 9. ААН-ийн зээлийн нийлүүлэлт, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.I улирлын хүлээлт	0.37	0.32	0	0.24	-0.30	0.38
2023.II улирлын хүлээлт	0.69	0.76	0.16	0.46	0.32	0.69

### 4.2 Иргэдийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд 2023 оны I улиралд иргэдэд 4.2 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 1.1 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлт болж, өмнөх улиралд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй нийцтэй гарсан байна. 2023 оны II улиралд банкууд иргэдэд олгох зээлийн нийлүүлэлтээ мөн нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 14).

**Зураг 14. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл**



- Банкууд 2023 оны II улиралд тэтгэврийн зээлээс бусад төрлийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Ялангуяа цалингийн, бизнесийн болон малчны зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 10).

<b>Хүснэгт 10. Иргэдийн зээлийн нийлүүлэлт, зээлийн төрлөөр</b>							
Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2023.I улирлын хүлээлт	0.46	0.46	-0.36	0.42	0.44	0.50	0.43
2023.II улирлын хүлээлт	0.40	0.77	-0.30	0.50	0.78	0.77	0.29

## Хавсралт 1. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар

- Хүснэгт 11-д 2023 оны I улиралд банкуудын ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлсөн хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар дэлгэрэнгүй харуулав. Нийт зээлийн хувьд банкуудын санхүүжилтийн боломж сайжирсан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдсэн, эдийн засгийн өсөлт нэмэгдсэн болон ерөнхий эрсдэл буурсан зэрэг хүчин зүйлс нь ААН-үүдийн зээлийн шалгуурыг сулруулахад голлон нөлөөлсөн байна.
- ХАА, боловсруулах үйлдвэр болон худалдаа, үйчилгээний салбарын зээлийн шалгуурыг сулруулахад санхүүжилтийн боломж сайжирсан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдсэн, тухайн салбарын нөхцөл байдал сайжирсан, барьцаа хөрөнгийн эрсдэл буурсан зэрэг хүчин зүйлс нь голлон нөлөөлсөн байна. Харин уул уурхай болон барилгын салбарын зээлийн шалгуурт төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна.

<b>Хүснэгт 11. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар</b> (2023.I улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
<b>Эх үүсвэрийн зардал, боломж</b>						
Эх үүсвэрийн өртөг	0.28	0.03	0.29	0.16	-0.06	0.30
Санхүүжилтийн боломж	-0.16	-0.47	0	-0.14	0.01	-0.35
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	-0.19	-0.24	0	-0.15	-0.01	-0.19
<b>Өрсөлдөөн</b>						
Бусад банкуудын өрсөлдөөн	-0.05	0	0	0	-0.19	0.02
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	-0.23	-0.23	0	0	0	-0.23
Санхүүгийн захын өрсөлдөөн	0	-0.23	0	0	0	0
<b>Эдийн засгийн байдал</b>						
Эдийн засгийн өсөлт	-0.11	-0.20	0.35	0.01	0	-0.06
Инфляци	0.09	0.03	0.29	0.15	0	0.12
Валютын ханш	0.08	0.03	0.26	0.14	0.15	0.12
<b>Эрсдэл</b>						
Тухайн салбарын төлөв байдал	-0.18	-0.23	0	-0.14	0	-0.18
Барьцаа хөрөнгийн эрсдэл	-0.19	-0.23	0	-0.14	0	-0.17
Банкны эрсдэл даах чадвар	-0.19	-0.23	0	-0.14	0	-0.18

## Хавсралт 2. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр

- Хүснэгт 12-т 2023 оны I улиралд банкуудын иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлсөн хүчин зүйлсийг зээлийн төрлөөр нь дэлгэрэнгүй тусгав. Нийт зээлийн хувьд бусад банкны өрсөлдөөн буурсан, эдийн засгийн өсөлт нэмэгдсэн, иргэдийн төлбөрийн чадвар сайжирсан, барьцаа хөрөнгийн эрсдэл буурсан болон банкны эрсдэл даах чадвар нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нь иргэдийн зээлийн шалгуурыг сулруулах чиглэлд голлон нөлөөлсөн байна.
- Хэрэглээний зээлээс бусад төрлийн зээлийн хувьд бусад банкны өрсөлдөөн буурсан, эдийн засгийн өсөлт нэмэгдсэн, иргэдийн төлбөрийн чадвар сайжирсан, барьцаа хөрөнгийн эрсдэл буурсан болон банкны эрсдэл даах чадвар нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нь зээлийн шалгуурыг сулруулах чиглэлд нөлөөлжээ.

<b>Хүснэгт 12. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр</b> (2023.I улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэв-рийн зээл	Хэрэглээ-ний зээл	Бизнес-ийн зээл	Малчны зээл	Автомашин-ны зээл
<b>Эх үүсвэрийн зардал, боломж</b>							
Эх үүсвэрийн өртөг	0	0	0	0.26	0	0	0
Санхүүжилтийн боломж	0	0	0	0.17	0	0	0
<b>Өрсөлдөөн</b>							
Бусад банкны өрсөлдөөн	-0.28	-0.20	-0.39	-0.13	-0.28	-0.27	-0.24
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0	0	0	0	0	0	0
<b>Эдийн засгийн байдал</b>							
Эдийн засгийн өсөлт	-0.27	-0.29	-0.39	0.04	-0.28	-0.27	-0.32
Инфляци	0	0	0	0.17	0	0	0
Валютын ханш	0	0	0	0.17	0	0	0
<b>Эрсдэл</b>							
Төлбөрийн чадвар	-0.25	-0.22	-0.39	-0.13	-0.28	-0.27	-0.24
Барьцаа хөрөнгийн эрсдэл	-0.25	-0.23	-0.39	-0.13	-0.28	-0.27	-0.24
Банкны эрсдэл даах чадвар	-0.25	-0.22	-0.39	-0.13	-0.28	-0.27	-0.24

### Хавсралт 3. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар

- Хүснэгт 13-т 2023 оны I улиралд ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар дэлгэрэнгүй байдлаар тусгав. Нийт зээлийн хувьд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлсөн байна.
- Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт нэмэгдсэн нь дийлэнх салбаруудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлжээ. Мөн зээлийн хүүний ерөнхий түвшин нь ХАА болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн бол барилгын салбарын зээлийн эрэлтийг бууруулах чиглэлд нөлөөлжээ. Харин дотоод санхүүжилт болон бусад банкуудаас зээлэх боломж нэмэгдсэн нь дийлэнх салбаруудын зээлийн эрэлтийг бууруулах чиглэлд нөлөөлсөн байна.

<b>Хүснэгт 13. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар</b> (2023.I улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	ХАА	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
<b>Санхүүжилтийн хэрэгцээ</b>						
Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт	0.40	0.47	0.19	0.30	0.43	0.49
Эргэлтийн хөрөнгө	0.60	0.62	0.49	0.55	0.62	0.59
Ажиллах хүчин болон тоног төхөөрөмж	0	0	0	0	0	0
Компанийн нэгдэл, бүтцийн өөрчлөлт	0	0	0	0	0	0
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0	0.47	0	0	-0.19	0.18
Өрийн дахин санхүүжилт	0	0	0	0	0	0
<b>Бусад санхүүжилтийн хэлбэрүүд</b>						
Дотоод санхүүжилт	-0.17	-0.23	0	-0.13	-0.15	-0.16
Бусад банкуудаас зээлэх	-0.19	-0.23	-0.06	-0.14	-0.19	-0.18
Бусад санхүүгийн байгууллагаас зээлэх	0	0	0	0	0	0
Үнэт цаас, хувьцаа гаргах	0	0	0	0	0	0
Гадаад зах зээлээс санхүүжилт татах	0	0	0	0	0	0

#### Хавсралт 4. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр

- Хүснэгт 14-т 2023 оны I улиралд иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийг зээлийн төрлөөр нь дэлгэрэнгүй харуулав. Нийт зээлийн хувьд удаан эдэлгээт барааны худалдан авалт болон хэрэглэгчийн итгэл зэрэг хүчин зүйлс эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлд голлон нөлөөлжээ.
- Цалингийн, хэрэглээний, бизнесийн, малчны болон автомашины зээлийг нэмэгдүүлэхэд иргэдийн удаан эдэлгээт барааны худалдан авалт голлон нөлөөлсөн байна. Мөн өрхийн хуримтлал буурсан нь хэрэглээний болон малчны зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд бага зэрэг нөлөөлжээ.

<b>Хүснэгт 14. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр</b> (2023.I улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
<b>Санхүүжилтийн хэрэгцээ</b>							
Удаан эдэлгээтэй бараа худалдан авалт	0.67	0.2	0.1	0.49	0.60	0.76	0.62
Хэрэглэгчдийн итгэл	0.1	0.1	0	0	0.1	0	0.1
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0	0	0	0	0	0	0
Өрийн дахин санхүүжилт	0	0	0	0	0	0	0
Үнэт цаас худалдан авалт	0	0	0	0	0	0	0
<b>Бусад санхүүжилтийн хэлбэрүүд</b>							
Өрхийн хуримтлал	0	0	0	0.2	0	0.2	0
Бусад банкуудаас зээлэх	0	0	0	0	0	0	0
Санхүүжилтийн бусад эх үүсвэр	0	0	0	0	0	0	0